

## **1. Их сургуулийн үндсэн оюутан**

### **(1) Элсэлт авах мэргэжлийн чиглэл:**

#### **Нийгмийн ухаан**

**Нийгмийн ухаан А:** Хууль зүй, Улс төр, Боловсрол судлал, Нийгэм судлал, Утга зохиол, Түүх, Япон хэл, Бусад

**Нийгмийн ухаан В:** Эдийн засаг, Менежмент

#### **Байгалийн ухаан**

**Байгалийн ухаан А:** Онолын байгалийн ухаан (Математик, Физик, Хими), Электрон, цахилгааны чиглэл (Электроникийн инженер, Цахилгааны инженер, Мэдээллийн технологи), Механикийн чиглэл (Механик инженер, Хөлөг онгоцны үйлдвэрлэл), Зам гүүр, архитектурын чиглэл (Зам гүүрийн инженер, Архитектур, Байгаль орчин), Хими (Хавсрага хими, Химийн технологи, Үйлдвэрийн хими, Нэхмэлийн инженер), Бусад (Металлург, Уул уурхай, Хөлөг онгоцны технологи, Биотехнологи)

**Байгалийн ухаан В:** Хөдөө аж ахуй (Газар тариалан, Хөдөө аж ахуйн хими технологи, Мал аж ахуй, Мал эмнэлэг, Ой судлал, Хүнс судлал, Загасны аж ахуй), Эрүүл мэнд (Эм зүй, Эрүүл мэнд, Сувилахуйн ухаан), Онолын байгалийн ухаан (Биологи)

**Байгалийн ухаан С:** Анагаах ухаан, Шүд судлал

### **(2) Болзол, шалгуур:**

- ① Иргэншил: Монгол Улсын иргэн байх.
- ② Нас: 1991 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс 1996 оны 4 дүгээр сарын 1-ний хооронд төрсөн байх.
- ③ Боловсрол: 2012 оны байдлаар Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагч (11,12-р анги), эсвэл дотоодын их, дээд сургуулийн 1, 2 дугаар курсийн оюутан байх.
- ④ Сурлагын дүн: Нийгмийн ухаан 3.2-оос дээш голч дүнтэй эсвэл 82-оос дээш голч оноотой, байгалийн ухаан 3.0-аас дээш голч дүнтэй эсвэл 75-аас дээш голч оноотой байх.  
*\*Голч дүн болон голч оноог дүнгийн жагсаалт дээр тодорхой тэмдэглэсэн байх шаардлагатай.*
- ⑤ Эрүүл мэнд: Бие, сэтгэцийн хувьд эрүүл байх.
- ⑥ Японд очих хугацаа: 2013 оны 4 дүгээр сарын 1-нээс 7-ны хооронд эсвэл 10 дугаар сарын 1-нээс 7-ны хооронд заасан хугацаанд Япон Улсад очих боломжтой хүн (Заасан хугацаанд Японд очиж чадаагүй тохиолдолд Японд очих зардлыг олгохгүй төдийгүй Япон Улсад суралцуулах боломжгүй болно).
- ⑦ Урд өмнө нь Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байсан бол сүүлийн тэтгэлэг авсан сарын дараа сарын нэгнээс тооцоход 2013 оны 4 сарын 1-ны байдлаар нутагтаа ирээд 3 -аас дээш жил болсон байх.
- ⑧ Цэргийн бус хүн байх

- ⑨ Японы их, дээд сургуульд суралцдаггүй байх.
- ⑩ Япон Улсын Засгийн газрын тэтгэлэг болон бусад байгууллагын тэтгэлэг, өөрийн улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх.

### **(3) Шалгаруулалт:**

- ① Бичгийн нэгдүгээр шалгалт  
Нийгмийн ухаан: Математик  
Байгалийн ухаан : Математик, Хими
- ② Бичгийн хоёрдугаар шалгалт (Бичгийн 1-р шалгалтанд тэнцсэгсэдээс авна)  
Нийгмийн ухаан: Англи хэл, Япон хэл  
Байгалийн ухаан А: Англи хэл, Япон хэл, Физик  
Байгалийн ухаан В, С: Англи хэл, Япон хэл, Биологи
- ③ Ярилцлагын шалгалт  
Бичгийн шалгалтад тэнцэгсэдээс ярилцлагын шалгалт авна.
- ④ Ярилцлагын шалгалтын дүнгээр 1 дүгээр шалгаруулалтанд тэнцэгсдийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яаманд нэр дэвшүүлнэ.
- ⑤ Дэлхийн улс, орон бүрээс нэр дэвшигчдийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яам сонгон шалгаруулж, эцсийн шийдвэрийг гаргана.

### **(4) Сургалтын агуулга:**

- ① Эхний 1 жил их сургуульд дэвшин суралцахад хэрэгтэй япон хэлний эрчимт сургалт болон бусад бэлтгэл сургалтанд хамрагдана.
- ② Бэлтгэл сургалт төгссөн оюутнууд Японы Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хувиарласан их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтанд тэнцсэний дараа тухайн их, дээд сургуульд элсэнэ. Оюутны нэгдүгээр шалгаруулалтын дүн, бэлтгэл сургалтын сурлагын дүн зэргийг харгалзаж үзсэний үндсэн дээр Японы Боловсрол, шинжлэх ухааны яам бэлтгэл сургалтын байгууллага болон их, дээд сургуультай зөвлөлдөн оюутны элсэлтийн шалгалт өгөх их, дээд сургуулийг сонгодог. Энэхүү шийдвэртэй холбоотой аливаа гомдол, саналыг хүлээн авахгүй.
- ③ Төгссөн оюутанд диплом, тухайн мэргэжлийн баклавр зэрэг олгоно.

## **2. Техникийн коллежийн оюутан**

### **(1) Элсэлт авах мэргэжлийн чиглэл:**

- ① **А групп:** Бодис, материалын инженер
  - ② **В групп:** Механик инженер, Цахилгаан, электроникийн инженер, Мэдээлэл, холбоо, сүлжээний инженер, Зам гүүр, барилга, Хөлөг онгоцны инженер, Бусад
- \* “Бусад” мэргэжлийн чиглэлээр суралцахыг хүссэн тохиолдолд тухайн салбараас шалтгаалан хүлээн авах сургууль олдохгүй байх тохиолдол гардаг.

**(2) Болзол, шалгуур:**

Их сургуулийн үндсэн оюутан элсүүлэх журамтай ижил бөгөөд сурлагын дүнгийн тухайд 1. (2). ④ – ийн байгалийн ухааныг үзнэ үү.

**(3) Шалгаруулалт:**

- ① Бичгийн нэгдүгээр шалгалт  
А групп: Математик, Хими  
В групп: Математик, Физик
- ② Бичгийн хоёрдугаар шалгалт  
А, В групп: Англи хэл, Япон хэл
- ③ Ярилцлагын шалгалт  
Бичгийн шалгалтанд эхний байранд орсон хүмүүсээс ярилцлагын шалгалт авна.
- ④ Ярилцлагын шалгалтын дүнгээр 1 дүгээр шалгаруулалтанд тэнцэгсдийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яаманд нэр дэвшүүлнэ.
- ⑤ Дэлхийн улс, орон бүрээс нэр дэвшигчдийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яам сонгон шалгаруулж, эцсийн шийдвэрийг гаргана.

**(4) Сургалтын агуулга:**

- ① Энэ ангиллын оюутан эхний 1 жил Японы Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хувиарласан бэлтгэл сургуульд элсэн орж, техникийн коллежид элсэн суралцахад шаардлагатай япон хэлний болон бусад эрчимжүүлсэн бэлтгэл сургалтанд хамрагдана.
- ② Бэлтгэл сургалт төгссөн оюутнууд Японы Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хувиарласан техникийн коллежид дэвшин суралцана. Дэвшин суралцах коллежийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яам, холбогдох сургуультай зөвлөлдөн шийддэг. Энэхүү шийдвэртэй холбоотой аливаа гомдол, саналыг хүлээн авахгүй.
- ③ Техникийн коллеж нь ЕБС-ийн дунд ангиас элсэлт авдаг 5 жилийн сургалттай сургууль боловч Засгийн газрын тэтгэлэгт оюутны хөтөлбөрийн дагуу суралцах оюутан 3 дугаар курсээс элсэн орж 3 жил (Хөлөг онгоцны инженер бол 3 жил 6 сар) мэргэжлийн мэдлэг эзэмшин төгсөнө. Төгсөхөд диплом олгоно.

**3. Мэргэжлийн сургуулийн оюутан**

**(1) Элсэлт авах мэргэжлийн чиглэл:**

Үйлдвэрлэл, Эрүүл ахуй, Боловсрол, нийгмийн халамж, Худалдаа, Хувцас чимэглэл, Интерьер дизайн, Соёл боловсрол, Бусад

\* “Бусад” мэргэжлийн чиглэлээр суралцахыг хүссэн тохиолдолд тухайн салбараас шалтгаалан хүлээн авах сургууль олдохгүй байх тохиолдол гардаг.

**(2) Болзол, шалгуур:**

Их сургуулийн үндсэн оюутан элсүүлэх журамтай ижил бөгөөд сурлагын дүнгийн тухайд 1. (2). ④ – ын байгалийн ухааныг үзнэ үү.

**(3) Шалгаруулалт:**

- ① Бичгийн шалгалт  
Математик, Англи хэл, Япон хэл
- ② Ярилцлагын шалгалт  
Бичгийн шалгалтанд тэнцэгсэдээс ярилцлагын шалгалт авна.
- ③ Ярилцлагын шалгалтын дүнгээр 1 дүгээр шалгаруулалтанд тэнцэгсдийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яаманд нэр дэвшүүлнэ.
- ④ Дэлхийн улс, орон бүрээс нэр дэвшигчдийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яам сонгон шалгаруулж, эцсийн шийдвэрийг гаргадаг.

**(2) Сургалтын агуулга:**

- ① Энэ ангиллын оюутан эхний 1 жил Японы Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хувиарласан бэлтгэл сургуульд элсэн орж, мэргэжлийн сургуульд элсэн суралцахад шаардлагатай япон хэлний болон бусад эрчимжүүлсэн бэлтгэл сургалтанд хамрагдана.
- ② Бэлтгэл сургууль төгссөн оюутнууд Японы Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хувиарласан мэргэжлийн сургуульд дэвшин суралцана. Дэвшин суралцах мэргэжлийн сургуулийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яам холбогдох мэргэжлийн сургуультай зөвлөлдөн шийддэг. Энэхүү шийдвэртэй холбоотой аливаа гомдол, саналыг хүлээж авахгүй.
- ③ Бэлтгэл сургалт төгссөн оюутан, хувиарлагдсан мэргэжлийн сургуулийнхаа ЕБС-ийн ахлах анги төгсөгчдийн элсэн орох боломжтой мэргэжлийн ангид элсэн орж, 2 жил мэргэжлийн мэдлэгт суралцана. Төгсөхөд диплом олгоно.

**4. Судлаач оюутан**

**(1) Элсэлт авах мэргэжлийн чиглэл:**

Японы их дээд сургуулиудад судалгаа хийх боломжтой бүх мэргэжлээр элсэлт авна.

- ① **Нийгмийн ухаан:** Утга зохиол, Түүх, Урлаг судлал, Хууль зүй, Улс төр, Эдийн засаг, Худалдаа, Сурган, Сэтгэл судлал, Нийгэм судлал, Хөгжим, Дүрслэх урлаг г.м
- ② **Байгалийн ухаан:** Онолын байгалийн ухаан, Инженер, Газар тариалан, Загасны аж ахуй, Эм зүй, Анагаах, Шүд, Гэр ахуй судлал г.м

*\*Японы их, дээд сургуульд судалгаа хийх боломжтой бүх мэргэжлээр элсэлт авах боловч хүлээн авах сургууль байхгүй зэрэг шалтгаанаас суралцуулах боломжгүй болох тохиолдол байдгыг анхаарна уу.*

**(2) Болзол, шаардлага:**

- ① Иргэншил: Монгол Улсын иргэн байх.
- ② Нас: 1978 оны 4 дүгээр сарын 2-ноос хойш төрсөн.
- ③ Боловсрол (Эдгээр болзлын аль нэгийг хангаж байх) :
  - (a) Баклаврын зэрэг авсан мэргэшлийнхээ дагуу үргэлжлүүлэн магистрантурт суралцаж байгаа хүн
  - (b) Докторантурт суралцаж байгаа хүн
  - (c) Магистр, докторын зэрэг хамгаалсан хүн.  
Докторын зэрэг хамгаалсан хүний тухайд Японд эрдмийн зэрэг авахыг зорилгоо болгоогүй тохиолдолд хүлээн авахгүй.
  - (d) Шалгаруулалтанд орох хүсэлт гаргах үедээ их сургууль төгсөөд зэрэг авсан мэргэжлээрээ 2 – оос дээш жил тасралтгүй ажиллаж байгаа
- ④ Сурлагын дүн: Их, дээд сургуулийг нийгмийн ухаан 3.2 –оос дээш голч дүнтэй эсвэл 82 – оос дээш голч оноотойгоор, байгалийн ухаан 3.0 –аас дээш голч дүнтэй эсвэл 75-аас дээш голч оноотойгоор тус тус төгссөн байх.
- ⑤ Мэргэжлийн салбар: Их, дээд сургуульд мэргэшсэн салбар болон түүнтэй хамаарал бүхий салбар. Японы их, дээд сургуульд судалгаа хийх бүрэн боломжтой салбар байх.
- ⑥ Эрүүл мэнд: Бие сэтгэлийн хувьд эрүүл байх.
- ⑦ Японд очих хугацаа: 2013 оны 4 дүгээр сарын 1-нээс 7-ны хооронд, эсвэл мөн оны 10 дугаар сарын 1-нээс 7-ны хооронд Японд очих боломжтой хүн. (Эдгээр хугацааны аль нэгэнд Японд очихоор төлөвлөсөн ч хүлээн авах сургуулийн боломжоос шалтгаалан өөрчлөгдөх тохиолдол байдаг)
- ⑧ Урьд өмнө нь Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байсан бол эх орондоо буцаж ирээд 3 – аас дээш жил сургалт, судалгааны байгууллагад ажилласан байх шаардлагатай. Гэвч үүнд “япон хэл, соёл судлаач оюутан” -аар суралцаж эх орондоо буцаж ирээд өмнө нь суралцаж байсан их, дээд сургуулиа төгссөн хүмүүс хамаарахгүй.
- ⑨ Японы их, дээд сургуульд суралцаж байгаа хүн хамрагдах боломжгүй.
- ⑩ Япон Улсын Засгийн газрын тэтгэлэг болон бусад байгууллагын тэтгэлэг, өөрийн улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байгаа бол оролцох боломжгүй.

**(3) Шалгаруулалт:**

- ① Бичгийн шалгалт  
Англи хэл, Япон хэл
- ② Ярилцлагын шалгалт  
Англи, япон хэлний аль өндөр оноо авснаар нь оноог тооцож, эхний байранд орсон хүмүүсээс ярилцлагын шалгалт авна.
- ③ Ярилцлагын шалгалтын дүнгээр 1 дүгээр шалгаруулалтанд тэнцэгсдийг Японы

Боловсрол, шинжлэх ухааны яаманд нэр дэвшүүлнэ.

- ④ Дэлхийн улс, орон бүрээс нэр дэвшигчдийг Японы Боловсрол, шинжлэх ухааны яам сонгон шалгаруулж, эцсийн шийдвэрийг гаргадаг.

\*Сонгон шалгаруулахад бичгийн шалгалт, ярилцлагын шалгалтаас гадна Японд хийх судалгааны ажлын төлөвлөгөөг чухалчлан үзнэ. Уг төлөвлөгөөг зөвхөн бичгийн шалгалтанд тэнцэгсдээс авна.

#### **(4) Сургалтын агуулга:**

- ① Хүлээн авах их сургууль нь элсэгчийн япон хэлний мэдлэгийг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд элсэгч эхний 6 сар орчим Японы Боловсрол, шинжлэх ухааны яамны заасан япон хэлний бэлтгэл курст суралцана. Япон хэлний бэлтгэл курсээ дууссан оюутан үндсэн их, дээд сургуульдаа элсэн орно.
- ② Нэгдүгээр шалгаруулалтад тэнцэгсэд элсэхийг хүссэн их дээд сургуультайгаа холбогдон “Элсэн орох зөвшөөрлийн бичиг” -ийг авна. Үүний дагуу Японы Боловсрол, шинжлэх ухааны яам тухайн сургуультай зөвлөлдөн, тухайн сургуульд элсүүлэх зөвшөөрлийг авсны дараа нэр дэвшигчийг тус сургуульд хувиарлана. (магистрантурын үндсэн оюутнаар элсэх зөвшөөрөл авсан тэнцэгчийг судлаач оюутнаар бус шууд магистрантурын үндсэн оюутнаар элсүүлнэ)
- ③ Судлаач оюутнаас магистрантурын үндсэн оюутнаар элсэн орох, эсвэл магистрантураас докторантурт элсэх тохиолдолд тухайн их дээд сургуулиас авдаг элсэлтийн шалгалтанд тэнцэх ёстой.

**ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ**